

2020 оны 04 сарын 07 өдөр  
№ 15718020

Мэдээлэл хүргүүлэх тухай

“Түмэн шувуут” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 18.00 цагт “Туушин” зочид буудлын хурлын танхимд хуралдахаар товлогдсон юм.

Монгол Улсын онцгой комиссын 2020 оны 03 сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор COVID-19 цар цахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс улсын хэмжээнд тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгаж, энэ хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг хориглоод байгаа тул манай компани Монгол Улсын Засгийн Газар, улсын онцгой комиссын шийдвэр, тогтоолыг биелүүлж ажиллахын зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Хувьцаат компаниудад гаргасан уриалгыг дэмжин “Түмэн шувуут” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “ЦАХИМ” хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Ийнхүү хурлаа “Цахим” хэлбэрээр зохион байгуулах гэж буй нь хувьцаат компаниудын хувьд анхдагч үйл явдал болж байгаа ба Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангаж ажиллахад бүрэн анхаарах болно.

Хавсралт:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн 06/2020 тоот тогтоол
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ж.БОЛД



2020 оны 04 сарын 06-ны өдөр

№ 06/2020

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
цахим хэлбэрээр хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, 76.1.18 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 сарын 19-ны өдрийн 64 тоот тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 сарын 05-ний өдөр нийт хувьцаат компаниудад хандан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах тухай мэдэгдэл болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 3 дугаар бүлэг, “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн 03/2020 тоот тогтоол, 2020 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Түмэн шувуут” Хувьцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2020 оны 04 сарын 22-ны өдрийн 18.00 цагт хуралдуулахаар товловсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т зааснаар Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Ж.Болд/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Л.ЭРХЭМБАЯР

## **“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

**Компанийн оноосон нэр:** “Түмэн шувуут” ХК

**Хурал болох өдөр, цаг:** 2020 оны 04 сарын 22-ны өдрийн 18.00 цагт

Хурал хуралдах хэлбэр: Компанийн фэйсбүүк хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 2020 оны цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
4. Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж батлах
5. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх.

**Бүртгэлийн өдөр:** 2020 оны 04 сарын 07-ны өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**

1. Компанийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай тайлан;
2. 2019 оны санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлт;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
5. Саналын хуудас;
6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын хурлын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2020 тоот тогтоол
7. Үнэт цаасны танилцуулгад орсон өөрчлөлтийн танилцуулга;
8. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компанийн цахим хуудсаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй Даваагаас Баасан гаргуудад 09-17 цагийн хооронд дор дурдсан хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож, санал өгөх талаархи дэлгэрэнгүй мэдээллийг компанийн цахим хуудас [www.tumenshuvuut.mn](http://www.tumenshuvuut.mn) хаяг болон фэйсбүүк хуудас facebook.com/tumenshuvuut-д хандаж авах боломжтой.

**Хаяг:** Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 21 дүгээр хороолол, 59 дүгээр байшин, “Түмэн шувуут” ХК-ийн оффис

**Харилцах утас:** 976-70005225

**Цахим шуудан:** narantsetseg@tumenshuvuut.mn

**Хурал зохион байгуулах комисс**